



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А25

Хужирт сум

Орон тооны бус зөвлөлийг татан
буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн "Тушаал хүчингүй болгох тухай" А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн "Шийдвэр хүргүүлэх тухай" 04/460 дугаар албан бичгийн дагуу Нийгмийн даатгалын багц хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх "Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох орон тооны бус байнгын зөвлөлийг татан буулгасугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Орон тооны бус байнгын зөвлөл байгуулах тухай" А/207 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА Д.БАТБАЯР

622401049

D:Alban bichig;Zahiramj 2024